

Living the Lotus 2

Buddhism in Everyday Life

2025
VOL. 233



«Рисшо Косей Кай Сан-Антонио салбарын нээлтийн ёслол» Талархал, зориг тэмүүлэл дүүрэн шинээр эхэллээ.

Living the Lotus
Vol. 233 (2025.02)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Т.Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Ш.Зоригмаа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Ирээдүй хойч үеэ бэлдэх

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Хүйтэн хөндий нийгмийг бүтээж буй зүйл бол ...

Гэнэт асуулт асууж байгаадаа хүлцэл өчье. Таны өмнө 3 ширхэг амтат жүрж байна гэж бодъё. Түүнийг хоёулаа хувааж идье гэвэл та яаж хуваах вэ?

Би энэ талаар номноос уншсан юм. Нэг сургуулийн багш 2 сурагчдаа 3 ширхэг амтат жүрж өгөөд “Үүнийг яаж 2 хуваах вэ?” гэж асуутал, нэг сурагч нь “Нэгийг нь Бурхан тахилдаа өргөөд, үлдсэнийг нь нэг нэгээр нь авна.” гэж хариулжээ. Тэгтэл багш нь “Юу яриад байгаа юм бэ, яг хоёр тэнцүү 1 бүтэн 1 тал гэж хуваана.” гээд шууд л үгүйсгэсэн байна.

Математикийн хувьд мэдээж хэрэг багшийн хэлсэн зөв боловч хүүхдийн зохиолч Ханаока Даигаку, хүүхдийн соёл судлаач Ёшиока Тасүкү нар энэ талаар ингэж ярьсан юм. “Бага насны хүүхдийн хүмүүжилд шашны мэдрэмжийг суулгах чухал бөгөөд хүний оюун ухааныг давсан оршихуйг эрхэмлэн дээдлэх ухамсар байхгүй байгаа нь хүмүүсийн сэтгэлд ус чийг үгүй, бусдыг бодох сөхөөгүй “хүйтэн хөндий ертөнц бий болсны том шалтгаан юм.”

Сүүлийн үед сургуулийн өдрийн хоол дээр “Манай хүүхдээр талархан идье гэж битгий хэлүүлээрэй” гэх ээж нар байдаг болсон гэж гений инженерчлэлийн нэрт мэргэжилтэн Мүраками Казүо гуайн номонд бичсэн байсан. Шалтгаан нь хоолны мөнгөө төлж байгаа учраас юм гэсэн.

Гэхдээ энэ үгний утгыг та бүгд ч гэсэн мэдэж байгаа байх. Мүраками Казүо гуай хэлэхдээ “«Талархан хүртье» гэдэг нь өөрийн амь насны төлөө бусдын амийг хүртэж байгаагаа хооллох болгондоо санаж, талархлаа илэрхийлэх үг юм.” гэжээ. Хамаг амьтныг ивээн тэтгэх агуу байгаль дэлхий, бурхан сахиус, мөн түүнчлэн зоогийн ширээн дээрх хоол ундыг бэлдэж, хүргэж өгсөн олон хүмүүст талархлаа илэрхийлэх үг буюу өөрөөр хэлбэл энэ нь “эрхэмлэн дээдлэх сэтгэл”-ийн илэрхийлэл билээ.



Ирээдүй “одоо, энд” бий

Гэхдээ би ингэж боддог юм. Японд олон хүн цагаан сар болохоор шинто хийгээд буддын сүм хийдэд очиж мөргөн, *хиган* (хавар, намрын өдөр шөнө тэнцэх өдөр, бурхны шашинд зургаан барамидыг хэрэгжүүлэн өвөг дээдсийнхээ сүнсийг амирлуулах өдөр гэдэг) болохоор өвөг дээдсийнхээ булшийг эргэж, үрабон болохоор бурхан болоочийн сүнсэнд алга хавсран мөргөж буян үйлддэг. Мөн Японы зан заншилд шинто шашин, бурхны шашин, Күнзийн сургаал номлол шингээд зогсохгүй барууны соёл ч хүлээн зөвшөөрөгддөг тул бид уужуу сэтгэлийг суулгадаг олон сургаалыг сурч боловсорч, тэдгээрийн зохицол дунд түүхийг бүтээсээр ирсэн.

Эрхэм дээд зүйлд залбиран мөргөх шашны соёл мэдээж хэрэг Японоос өөр бусад оронд ч бий. Нэг ёсондоо хэн бүхэнд сүслэн дээдлэх сэтгэл оршдог гэж хэлж болно. Тэгэхээр үүнийг мартсан хүний сүслэн дээдлэх сэтгэлийг сэргээж, хүүхэд багачуудад эцэг эх, томчууд эрхэм зүйлийг хүндлэн дээдэлж амьдарч буй дүр зургийг харуулах чухал. Энэ утгаараа өдөр бүрийн судар уншлага бол маш том боломж юм.

Учир нь ирээдүйн эхлэл “яг одоо” болохоор тэр. Бид яг одоо, энд өөрийн сэтгэлийг өнгөлөн зүлгэж, чадах зүйлээ хичээнгүйлэн хийх нь дараагийн үеийг бүтээх үр хүүхэд, ач зээгийнхээ сэтгэлийг хөгжүүлж, бүгд бие биенийхээ бурханлаг чанарт итгэдэг “ирээдүйг бэлдэж” байгаа хэрэг юм. Нөгөөтэйгүүр бид өөрсдөө өсөж хөгжих тусам ирээдүй өнгөлөг гэгээлэг болно гэсэн үг.

Балчир насны хүүхдийн хүмүүжлийн талаар нэмж хэлэхэд эцэг эх нь өдөр тутамдаа бурхан сахиусанд алга хавсран мөргөж, амар амгалан, зөөлөн дулаан гэр бүлийг бүтээх нь юу юунаас ч илүү чухал хүмүүжил болно. Мэргэжилтнүүд хүүхдийг хэвлийд байхад нь судар ном уншихын чухлыг ярьж хэлэлцдэг нь ч гэсэн эхийн сэтгэл тайван тогтвортой байх нь хэвлий дэх хүүхдэд нь сайн үр нөлөө үзүүлж, эх үрийн холбоо гүнзгийрдэгтэй холбоотой.

Тэгэхээр амар амгалан гэр бүлийг бий болгохын төлөө “баярлалаа”, “талархан идье”, “сайхан хооллолоо” гэсэн гурван үгний утгыг тунгааж бодож, өдөр бүр чин сэтгэлээсээ хэлдэг байх дадлыг суулгавал зохилтой. Эцэг эхийн ийм үлгэр дуурайл ирээдүй хойч үеийн сэтгэлийг чийглэж, хөгжүүлдэг билээ.

“Косей” сэтгүүл, 2-р сарын дугаараас



Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

Нийгэмлэгийн тэмдэглэлт баяр ёслолууд

Үүсгэн байгуулагчийн төрсөн өдөр


11-р сарын 15 бол Үүсгэн байгуулагчийн төрсөн өдрийн баярыг тэмдэглэдэг өдөр юм.

Тэрээр 1906 оны 11 сарын 15-ны өдөр Нийгата мужийн Тоокамачи хотын Сүганүма тосгонд төржээ. Токиод нүүж ирээд Цагаан лянхуа судартай учирсанаар сургаалыг түгээн хүн төрөлхтнийг аварч, нийгмийг шинэчлэн

бүтээх зорилгын дор Рисшо Косей Кай нийгэмлэгийг үүсгэн байгуулсан.

Үүсгэн байгуулагчийн ачаар бид Цагаан лянхуа судартай учирч аз жаргалын замаар алхаж байгаа билээ.

Энэ өдөр бид түүний үзэл санааг тунгаан бодож, ач буянд нь дахин талархах учиртай.



Бяцхан мэдлэг

Буддын шашинд “Дөлгөөн царай, эелдэг үг” гэсэн хэллэг бий. Энэ нь зөөлөн дулаан төрх, эелдэг үгээр хүнтэй харилцах гэсэн утгатай. Гэгээхэн инээмсэглэл, халуун дулаан үгээрээ олон түмэн, нийгмийг гэрэлтүүлж явсан Үүсгэн байгуулагч маань үнэхээр дөлгөөн тогтуун төрхтэй, эелдэг сайхан үгтэй хүн байсан юм.

* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



Амин өдөр



Сарын 1-н, 15-ны амин өдрөөр өдөр тутмынхаа зам мөрийг эргэцүүлэн бодож, номын нөхөдтэйгөө баяр баясгалан, гэмшилээ хуваалцан ярилцдаг. Мөн сургаалыг түгээн дэлгэрүүлэх хүсэл зорилгоо сэргээдэг.

Амин өдөр Бурхан багшийн сургаалд талархаж, түүнийг бусдад түгээн дэлгэрүүлэхээ тангарагладаг ба Рисшо Косей Кай нийгэмлэг доорх амин өдрийн ёслолыг үйлддэг.

Бяцхан мэдлэг

"Амин өдөр" гэдэг нь хүний нас барсан өдрийг хэлдэг. Амин өдрөөр тухайн хүний дуртай зүйлсээр тахилын ширээ засах зэргээр чин сэтгэлийн өргөл өргөдөг. Рисшо Косей Кай нийгэмлэгт Гол шүтээн залсан өдөр зэрэг бурхны сургаалтай учирсан өдрийг ч бас амин өдөр хэмээдэг.

1-ний өдөр (Сарын эхний мөргөлийн өдөр): Ерөнхийлөгчийн айлдварыг тунгаан бодож, сүсэг бишрэл бүхий амьдралынхаа чиг шугам болгож, тухайн сарын зорилгоо тодорхойлдог.

4-ний өдөр (Үүсгэн байгуулагчийн амин өдөр): Үүсгэн байгуулагчийг дурсан санаж, магтау сайшааж, ач буянд нь талархаж, үйл хэргийг нь залгамжлахаа тангарагладаг.

10-ны өдөр (Мёокоо багшийн амин өдөр): Хамтран үүсгэн байгуулагчийн энэрэнгүй сэтгэлийн үлгэр жишээгээр амьдрахаа тангарагладаг.

15-ны өдөр (Шагжамүни бурхны амин өдөр): Авралд хүрэх замыг зааж өгсөн Шагжамүни бурханд талархал илэрхийлэх өдөр. Мөн "Сарын эхний мөргөл"-өөр тодорхойлсон зорилгоо эргэн санаж, дүгнэлт хийхийн зэрэгцээ үлдсэн хагас сарын зорилгоо тодорхойлдог.

* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.

Хаврын эртэд төрсөн бодол

Акагава Кэйичи

Та бүхний амгаланг айлтгая.

1-р сарын 20-ноос эхэлсэн өвлийн номын уншлага амжилттай дуусаж, цаг тооллоор Японд 2 сарын 3-ны өдрөөс хаврын урин цаг ирэх гэж байна. Токиод хүйтэн өдрүүд үргэлжилсээр байгаа ч хавар цаг ирснийг зарлах мэт интоорын мод цэцэглэж буй мэдээ хол ойроос үе үе сонсогдох боллоо. Өдөр бүр ажилдаа явах замдаа байгаль дэлхийн үзэмж, салхины чимээгээр улирал солигдож буй нарийн өөрчлөлтийг мэдэрч, өвлийн турш унтаа байсан амьдрал аажмаар сэргэж байгааг харахаар сэтгэл баясан догдолно. Хавар хаяанд иржээ.

2-р сард Буддын шашны гурван том баярын нэг болох “Бурхан багшийн нирваанд орсон өдрийн ёслол” болох ба Косей кай нийгэмлэг ч гэсэн Их Ариун Ордонд томоохон хэмжээний үйл ажиллагааг зохион байгуулна. Үүгээр дамжуулан би Бурхан багшийн нирваан дүр үзүүлсэний утга учрыг тунгаан бодож, гэргийтэн хүний хувиар өдөр бүр бурхны үйлд хичээнгүйлэн зүтгэхээ дахин тангараглахыг хүсэж байна. Нивано ерөнхийлөгчийн энэ сарын айлдвараас “Бид хэдий чинээ өсөж сайжирна төдий чинээ гэрэлт ирээдүйг бүтээж чадна.” гэдгийг суралцлаа. Үүний тулд хэрхэн Цагаан лянхуа судрыг амьдралдаа хэрэгжүүлэхээ тунгаан бодож, сургаалаар дамжуулан аз жаргалыг мэдрэхийн тулд өдөр тутмын амьдралдаа бие, хэл, сэтгэлээрээ сургаалыг дагахын хамтаар могой жилд хуучны өөрөөсөө салж урагшлан сайжрахыг хичээх болно.




2024 оны 12 сарын 8-ны өдөр Сан Антонио салбарын нээлтийн ёслолоор цэцэг өргөсөн гишүүдийн хамт

Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about local Dharma centers



facebook



X

